

2025 ОНЫ 02 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 02 дугаар сарын 06-ны “Пүрэв” гарагийн 12:00 цагаас өмнө** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.

8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа (20МВт) дулааны цахилгаан станцын ажлын явцыг танилцуулах.	БҮТП ХК
2	Хот нийтийн аж ахуйн чиг үүргийн ажлуудаа эрчимжүүлж ажиллах. Үүнд: Хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, нохой, муур устгах, нийслэлээс мал гаргах зэрэг.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт, ХААТ, Хороод
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
3	Дүүргийн хэмжээнд 2025 онд хийгдэх зам засварын ажлыг хугацаанд нь эхлүүлэх хүрээнд ажлын даалгаврыг боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтантай уулзаж ажлын чанар, гүйцэтгэлтэй газар дээр нь очиж танилцах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ
4	Их, дээд сургууль, коллежд суралцаж буй дүүргийн харьяат оюутнуудад 2025 оны 02 дугаар сарын 20-25-ны өдрүүдийн хооронд дүүргийн хэмжээнд дутагдалтай байгаа ажлын байрны сул орон тоо, боломж нөхцлүүд, БҮТП-д хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, ажлын байрны мэдээлэл, ирээдүйд бий болох ажлын байр, боловсон хүчин, 2023, 2024 онуудад дүүрэгт хийгдсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд, 2025 онд хийгдэх ажлын төлөвлөгөө, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн өөрчлөлтийн хүрээнд дагуул хот болох эрх зүйн үндэс	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, НХХ, ХХҮХ, БҮТП ХК

	бүрдсэнээр ямар өөрчлөлтүүд хийгдсэн, цаашид хэрхэн хөгжих талаарх мэдээллийг бэлтгэн танилцуулах.	
5	“Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх” зорилтот жилийн нээлтийн арга хэмжээний бэлтгэлийг сайтар ханган, аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэдийн оролцоог хангах.	ЗДТГ, Нийт байгууллагууд
6	ЕБС, СӨББ-уудын удирдлагуудтай 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор холбогдох гэрээ байгуулах.	ТЗУХ, НХХ, ЕБС, СӨББ-ууд
7	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагууд орчны цэвэрлэгээ үйлчилгээгээ сайжруулах, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гадна орчны аюулгүй байдлыг хангуулах, хяналт тавих ажлаа эрчимжүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, нийт байгууллага
8	Хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй ажлуудын гүйцэтгэлийг сайжруулах хүрээнд холбогдох байгууллага, албан тушаалтантай уулзаж, ажлыг яаралтай дуусгах.	ЕБС, Илч-Орд ОНӨААТҮГ

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР